



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ
САЙДЫН ТУШААЛ

2002 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 321

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

"Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2002 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн хурлын тэмдэглэл, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын 2,6-г үндэслэн ТУШААХ НЬ:

1. Дашдэлэг овогтой Алтансүхийг 2002-2003 оны хичээлийн жилээс АНУ-ын Southwest Missouri Улсын Их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар суралцуулсугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/, энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД

А.ЦАНЖИД



Хуучинбар үрэн; С/т З.Тхтаргал
2002.11.08